



Strong
UN.
Better
World.

UNITED NATIONS IN MONGOLIA
МОНГОЛ УЛС ДАХЬ НЭГДСЭН
ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА

© United Nations in Mongolia
October 2015

UN Mongolia
UN House, United Nations Street-14, Sukhbaatar District,
Ulaanbaatar 14201, Mongolia

Web: www.un-mongolia.mn
Facebook: www.facebook.com/unmongolia
Twitter: www.twitter.com/unmongolia

FOREWORD

Mongolia has been an active member of the United Nations since it joined as the 101st member in 1961. Over the past 5 decades, the relationship between the UN and Mongolia has matured into a strong and mutually beneficial partnership. The United Nations in Mongolia consist of 11 agencies that contribute to development across various sectors ranging from the promotion of human rights, to support to democratic governance, to fostering socio-economic development as well as facilitating access to quality public services such as health, education, water, sanitation and protecting the environment. Mongolia has become an increasingly important contributor to UN peace keeping operations currently providing 944 troops to operations in 5 countries.

2015 does not only mark the 70th anniversary of the UN. It also represents a once in a generation opportunity in development with four key agenda setting conferences taking place in a single year including the UN World Conference on Disaster Risk Reduction, the International Conference on Financing for Development, the Sustainable Development Summit and the Climate Change Conference. On 25 September, all 193 member states adopted the **2030 Agenda for Sustainable Development**. Its Sustainable Development Goals (SDGs) set out the global priorities for both people and planet. The SDGs are a call to action to end global poverty, fight inequality, protect the planet and ensure that all human beings enjoy peace and prosperity without leaving anyone behind.

The United Nations in Mongolia sees it as our main priority to support Mongolia in ensuring that economic growth and development progress are truly inclusive and equitable while at the same time safeguarding its natural resources for future generations. To make this happen we are striving to build an ever more relevant UN for Mongolia. This is a UN that generates top notch and timely advice for Mongolian policy makers. It is also a UN that has the trust to work on difficult and complex issues in the Mongolian development context today and tomorrow.

We are delighted to present this brochure that provides a brief description of the UN agencies in Mongolia and a snap shot of our work as **'One UN'**.

Ms. Beate Trankmann
United Nations Resident Coordinator/UNDP Resident Representative

УДИРТГАЛ

Монгол улс 1961 онд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-д 101 дэх гишүүн орноор элсэн орсноос хойш энэхүү байгууллагын идэвхитэй гишүүн нь байж ирсэн. Өнгөрсөн 50 гаруй жилийн хугацаанд Монгол улс болон НҮБ-ын харилцаа харилцан ашигтайгаар хөгжиж ирсэн. Одоогийн байдлаар Монгол улсад НҮБ-ын 11 төрөлжсөн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд эдгээр байгууллага нь хүний эрх, ардчилал, сайн засаглал, нийгэм эдийн засгийн салбарт өөрсдийн хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Ялангуяа, чанартай хүртээмжтэй эрүүл мэнд, боловсрол болон бусад төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах, байгаль орчноо хамгаалах зэрэг талбарт идэвхтэй ажиллаж байна. Монгол Улс нь НҮБ-ын энхийг сахиулах үйл хэрэгт хувь нэмрээ оруулагч чухал орны нэг болсон бөгөөд эдүгээ 5 улсад 944 энхийг сахиулагчдаа илгээгээд байна.

2015 онд НҮБ-ын 70 жилийн ойг тэмдэглэж байгаараа онцлогтой бөгөөд үүгээр зогсохгүй энэ онд Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн Бага хурал, Хөгжлийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх тухай Олон улсын Бага хурал, Тогтвортой хөгжлийн тухай Дээд хэмжээний уулзалт, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Олон улсын Бага хурал зэрэг 4 том хөгжлийн хөтөлбөрийг тодорхойлох уулзалтууд нэг жилийн дотор болсноороо их онцлог жил болж байна. Мөн энэ оны 9 сарын 25-нд НҮБ-ын гишүүн 193 улс орон **2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөрийг** баталсан билээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд тогтвортой хөгжлийн зорилгуудыг хүн төрөлхтөн болон эх дэлхийн сайн сайхны төлөө дэвшүүлсэн. Тогтвортой хөгжлийн зорилгууд нь хэнийг ч орхилгүй, ядуурлыг устгаж, тэгш бус байдлыг халж, эх дэлхийгээ хамгаалж, хүн төрөлхтөн амар амгалан, хөгжин цэцэглэхийн төлөөх уриа юм.

Монгол улс дахь НҮБ-ын байгууллагуудын үндсэн тэргүүлэх чиглэл нь Монгол улсыг хөгжлийнхөө үр шимийг нийт ард иргэддээ тэгш хүртээж, ирээдүй хойч үедээ байгалийн баялгаа хадгалж үлдээж чадахуйц эдийн засгийн өсөлтийг бий болгоход нь тусалж, дэмжиж ажиллах явдал юм. Үүний төлөө Монгол улс дахь НҮБ-ын байгууллагууд бүхий л нөөц боломжоо дайчлан ажиллаж байгаагаас гадна өөрсдийгөө ч мөн өөрчлөн, бодлогын түвшинд ажиллаж, Монгол улсын бодлого боловсруулах түвшинд цаг хугацаа алдалгүй, оновчтой шийдэл гаргахад зөвлөмж өгч, хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдэхэд итгэмжлэгдсэн түнш байхыг зорьж байна.

Монгол улс дахь НҮБ-ын байгууллагуудын **"Нэг НҮБ"** уриан доор хийсэн ажлын талаарх энэхүү товч танилцуулгыг Та бүхэнд хүргэж байгаадаа баяртай байна.

Биата Транкман
НҮБ-ын Суурин зохицуулагч/НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч



Food and Agriculture
Organization of the
United Nations

FOOD AND AGRICULTURE ORGANIZATION OF THE UNITED NATION'S НҮБ-ЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГА

The Food and Agriculture Organization of the United Nations (FAO) has a history of partnership with the Government of Mongolia (GoM), to eradicate poverty and malnutrition through the development of the agriculture sector. It has, also, been an active partner of the government in protecting the environment and promoting sustainable development and disaster risk management strategies of the country. All of those collaboration has started since 1973, when Mongolia became of a member of the FAO and the country office was accredited through the FAO Office in Beijing, China. In July 2009, a dedicated FAO Mongolia Office was established in Ulaanbaatar; with the FAO Representative in China accredited as its head. Locally, the vision of FAO Mongolia Country Office is *“to be a leading, credible and responsive partner in ensuring food and nutrition security of the population”*. Over the past years, FAO has supported interventions in research, natural resources management, technology transfer, food and agriculture policy, livestock production systems management, emergency and post crisis management, forestry information, statistics, food security and nutrition, emergency response operations, crop production system management, and food quality and safety.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (НҮБ-ын ХХААБ) нь хүнс, хөдөө аж ахуй (загас, ой, байгалийн нөөцийн менежмент), хүнсний аюулгүй байдалтай холбогдсон бүх асуудлаар дэлхий дахинд үйл ажиллагаа явуулдаг Нэгдсэн үндэстний байгууллагын төрөлжсөн агентлаг юм. 1973 онд Монгол Улс НҮБ-ын ХХААБ-ын гишүүн орноор элсэж, 2009 онд Улаанбаатар хотноо албан ёсны Шадар суурин төлөөлөгчийн газрыг нээсэн. ХХААБ нь Монгол Улсад эрдэм шинжилгээ, байгалийн нөөцийн менежмент, технологи дамжуулалт, хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, мал аж ахуйн үйлдвэрлэлийн менежмент, онцгой байдал ба гамшгийн дараах менежмент, ойн мэдээлэл, статистик, хүнсний чанар, аюулгүй байдал зэрэг өргөн хүрээнд техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлсээр ирсэн.



Selenge, Mongolia /2015
Mongolian beekeepers are trained on rearing queen bees and stock reproduction for enhancing productivity and quality of bee farming

Сэлэнгэ аймаг/2015
Монголын зөгий үржүүлэгчид хатан зөгий өсгөх, сүргийн нөхөн үржүүлэлтийн талаар чадвар эзэмшиж байгаа нь

Technical assistance is provided to increase a consumption of organic honey, Mongolian beekeepers learn techniques of rearing queen bees and stock reproduction through South and Southern Cooperation's capacity building interventions.

Органик зөгийн балын хэрэглээ нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэн Өмнөд Өмнөдийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Монголын зөгийчид үржлийн хатан зөгийн бойжуулах арга техникт суралцан зөгийн аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чадамжтай боллоо.



Children's palace/ 2014

Children actively participated in the Drawing Contest on Save food and Reduction of food waste

Хүүхдийн ордон/ 2014

"Хүнсээ хэмнэе" үндэсний хэмжээний аяны зургийн уралдаанд хүүхдүүд идэвхтэй оролцов.

Denouncing the huge amount of food that goes to waste, Ministry of Food and Industry of Mongolia and the FAO cooperatively launched a nation-wide campaign on Save Food aimed at stopping post-harvest food losses and market-to-consumer food waste. Children and youths actively participated in the campaign to promote public awareness on food losses and waste reduction.

Их хэмжээний хоол хүнсийг хаягдал болгож байгааг зогсоохыг уриалан Монгол улсын Хүнс, Хөдөө аж ахуйн яам, НҮБ-ын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага хамтран "Хүнсээ хэмнэе" үндэсний хэмжээний аянг зарлан хэрэгжүүлэв. Аяны гол зорилго нь ургац хураалтын дараах хүнсний ногооны хорогдлыг болон үйлдвэрлэгчээс хэрэглэгчид хүрэх шатан дахь хүнсний хаягдлыг бууруулах явдал юм. Хүүхэд, залуучууд энэхүү аянд идэвхтэй оролцов.



Galuut soum, Bayankhongor province/ 2015
Fodder crop field demonstration trial
conducted for the rural herders and farmers in
high mountain zone of Mongolia

Баянхонгор аймгийн Галуут сум/2015
Өндөр уулын бүс нутагт гэжээлийн ургамал
тариалах талбайн үзүүлэх сургалт

The Rural-Invest tool newly introduced by UN FAO is used to promote herder community participation for designing and prioritizing investment for agriculture and livestock. Herders and rural vulnerable people developed 86 projects aimed to increase rural livelihood and food security and enhance livestock productivity with RIV model and got funding and implemented projects successfully under the local technical service providing NGOs.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас шинээр нэвтрүүлсэн Хөдөөгийн Хөрөнгө оруулалт аргачлалыг ашиглан малчид хөрөнгө оруулалтын хэрэгцээнд тохируулан бизнес төлөвлөгөө боловсруулах чадвартай боллоо. Уг аргачлалаар боловсруулсан 86 төсөл амжилттай хэрэгжиж байна.



INTERNATIONAL LABOUR ORGANIZATION ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГА

Mongolia, a member of the ILO since 1968, is committed to the ILO Declaration on Fundamental Principles and Rights at Work by ratifying ILO's all eight fundamental conventions, covering the elimination of child and forced labour, freedom of association and the effective recognition of the right to collective bargaining, and elimination of discrimination in employment and occupation. The country's national tripartite social dialogue, introduced and supported by the ILO in early 1990s, brings government, workers and employers to discuss policies and programmes, and other decisions that affect social partners, including aligning national laws and practices to international labour standards. Current ILO programmes, to name a few, focus on improving labour market governance, promoting decent work, enhancing income security for all through the implementation of a social protection floor, promoting equality of opportunity and treatment and inclusiveness in employment and ensuring occupational safety and health at work.

Монгол улс 1968 онд ОУХБ-ын гишүүн болсон бөгөөд ОУХБ-ын суурь найман конвенцид нэгдэн орсноор ОУХБ-ын Хөдөлмөрийн хүрээний суурь эрх, зарчмуудыг хүлээн зөвшөөрсөн билээ. Албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийг устгах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг дээдэлж, хөдөлмөр эрхлэлтэнд ялгаварлан гадуурхахгүй байх нь ОУХБ-ын үндсэн зарчим бөгөөд энэ чиглэлээр техникийн туслалцаа үзүүлэн ажиллаж байна. ОУХБ-ын дэмжлэгтэйгээр 1990-ээд оны эхээр үндэс сууриа тавьсан үндэсний гурван талт нийгмийн түншлэлийн хүрээнд Засгийн газар, ажилчид болон ажил олгогчдын төлөөлөл тэдэнд хамаарах аливаа бодлого, хөтөлбөрийг хэлэлцэх, шийдвэр гаргах зэрэгт оролцдог болов. Өнөө ОУХБ-ын үйл ажиллагаа нь хөдөлмөрийн удирдлагыг хөгжүүлэх, зохистой хөдөлмөрийг дэмжих, нийгмийн хамгааллын суурь түвшинг тогтоох замаар нийт хүн амын орлогыг баталгаажуулах, тэгш хүртээмжтэй хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, ажлын байранд ялгаварлан гадуурхалтыг арилгах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах зэрэг олон салбарыг хамарч байна.



Football match – World day against Child Labour. ILO/Yo.Nyamdavaa/2011

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдөрт зориулсан хөл бөмбөгийн тэмцээн. ОУХБ/Ё.Нямдаваа/2011

Since 2005, the ILO has provided technical and financial support to eliminate the worst forms of child labour in Mongolia which resulted in approval of the list of hazardous jobs for minors in 2008, integrating efforts of government and non-government organizations by establishing a national network, increasing awareness raising of safety of child jockeys, conducting national child labour surveys in every 4 years, and development of institutional framework of career guidance.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага нь 2005 оноос хойш Монгол улсад хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах чиглэлээр санхүү, техникийн тусламж үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд үүний үр дүнд насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг 2008 онд баталж, төр болон төрийн бус байгууллагуудаас бүрдсэн үндэсний сүлжээг байгуулахыг дэмжсэн билээ. Түүнчлэн, морь унаач хүүхдийн аюулгүй байдлын асуудлыг гаргаж тавин, үндэсний хэмжээнд хүүхдийн хөдөлмөрийн судалгааг 4 жил тутам хийдэг болов. Мөн мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний тогтолцооны суурийг тавив.



ILO has provided support to improve capacity of private and public employment services to promote employment of persons with disabilities.
ILO/B.Byamba-Ochir/2012

ОУХБ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг сайжруулах чиглээр төр, хувийн хэвшлийн зуучлалын байгууллагуудын чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлэв.
ОУХБ/Б.Бямба-Очир/2012

ILO has provided support to improve capacity of private and public employment services to promote employment of persons with disabilities.

ОУХБ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг сайжруулах чиглээр төр, хувийн хэвшлийн зуучлалын байгууллагуудын чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлэв.



Young herders, Bayankhongor province.
ILO/N.Munkhbaatar/2014

Залуу малчид, Баянхонгор аймаг. ОУХБ/
Н.Мөнхбаатар/2014

With technical support of the ILO, Mongolia's government and social partners have defined and committed to implementing a national social protection floor for all including extending the old age pension insurance coverage to herders, self-employed and informal economy workers in Mongolia.

Монгол Улсын Засгийн газар, нийгмийн түншүүд ОУХБ-ын дэмжлэгтэйгээр үндэснийхээ нийгмийн хамгааллын суурь түвшинг тодорхойлж хэрэгжүүлэх, тэр дундаа малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдыг өндөр насны тэтгэврийн даатгалын асуудлаар хамтран ажиллаж байна.



JOINT UNITED NATIONS PROGRAMME ON HIV/AIDS

*Zero new HIV infections.
Zero discrimination.
Zero AIDS-related death*

The Joint United Nations Programme on HIV/AIDS (UNAIDS) unites the efforts of 11 UN organizations and works closely with global and national partners towards ending the AIDS epidemic by 2030. As a focal point for information, expertise and resources, UNAIDS in Mongolia plays a critical role in connecting UN agencies, government and development partners and civil society organisations to achieve their joint visions.

For more information, please visit: www.unaids.org ,
www.un-mongolia.mn/unaids

НҮБ-ЫН ДОХ-ЫН НЭГДСЭН ХӨТӨЛБӨР

*ХДХВ-ын шинэ халдварыг тэглэх
Ялгаварлан гадуурхалтыг тэглэх
ДОХ-оос үүдэлтэй нас баралтыг тэглэх*

НҮБ-ын төрөлжсөн 11 байгууллагын дэмжлэг, хүчин чармайлтыг нэгтгэсэн НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн Хөтөлбөр (UNAIDS) нь 2030 он гэхэд ДОХ-ын тархалтыг таслан зогсоохын төлөө улс орнуудтай хамтран ажиллаж байна.

Монгол улс дахь НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөр нь мэдээлэл, мэргэжил арга зүй болон нөөц дайчлах чиглэлээр НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, мөн бусад түнш, хандивлагчдыг хамтын зорилгодоо хүрэхэд холбох гүүр нь болдог.

Дэлгэрэнгүй мэдээллийг: www.unaids.org, www.un-mongolia.mn/unaids



Photo: Mareike Günsche
Зургийг: Марике Гүнше

Prevailing stigma and discrimination for people living with HIV (PLHIV) in all spheres of society prevents people from getting tested for HIV and knowing their status. In recent years, there have been positive policy and legal changes in Mongolia to protect the rights of PLHIV and eliminate HIV-related discrimination for which UNAIDS contribution was significant.

ДОХ-той хүмүүсийг нүд үзүүлэх, ялгаварлан гадуурхах байдал нийгмийн бүх хүрээнд байдаг тул ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд орохоос хүмүүс зайлсхийдэг. ХДХВ, ДОХ-той амьдарч буй хүний эрхийг хамгаалах, ялгаварлан гадуурхалтыг бууруулах чиглэлээр Монгол улсын хууль эрх зүй, бодлогын орчинд олон зэрэг өөрчлөлт сүүлийн жилүүдэд гарсан. Үүнд НҮБ-ын оруулсан хувь нэмэр өндөр юм.



*Empowered lives.
Resilient nations.*

UNITED NATIONS DEVELOPMENT PROGRAMME НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

UNDP works in more than 170 countries and territories, helping to achieve the eradication of poverty, and the reduction of inequalities and exclusion. We help countries to develop policies, leadership skills, partnering abilities, institutional capabilities and build resilience in order to sustain development results.

UNDP opened its representative office in Ulaanbaatar in 1973 after more than a decade of successful cooperation with the Government of Mongolia. UNDP is committed to helping the Government and the people of Mongolia achieve its nine national Millennium Development Goals as well as other national development priorities through capacity development, knowledge sharing, partnerships, and policy dialogue.

Following the adoption of the 2030 Agenda for Sustainable Development, UNDP aims to help countries adopt the global goals to the national context. This will be done by mainstreaming the goals into national and local development plans and budgets and by providing policy advice and support to accelerate implementation of the agenda.

In all our activities, we encourage the protection of human rights and the empowerment of women, minorities and the poorest and most vulnerable.

For more to learn about UNDP Mongolia please visit:
www.undp.org, www.mn.undp.org

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь дэлхийн 170 гаруй орон, газар нутагт ядуурлыг бууруулах, тэгш бус, ялгаатай байдлыг арилгахын төлөө ажилладаг. Бид улс орнуудын бодлого боловсруулах, манлайллын ур чадвар, түншлэл хамтын ажиллагаа, байгууллагын боломж чадавхийг бэхжүүлэх, хөгжлийн үр шимийг тогтвортой хадгалах үйлсэд тусалж байна.

НҮБХХ Монгол улсад арав гаруй жил амжилттай хамтран ажилласны дараа 1973 онд суурин төлөөлөгчийн газраа нээсэн бөгөөд хүн бүрийн сайн сайхан амьдралын төлөө олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Мянганы хөгжлийн зорилтуудад хүрэх болон үндэсний хөгжлийн тэргүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чадавхийг бэхжүүлэх, мэдлэг туршлага хуваалцах, бодлогын хэлэлцүүлгийг өрнүүлж ирсэн.

2030 онд хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд НҮБХХ улс орнуудад үндэсний түвшинд зорилтуудаа тодорхойлох, үндэсний болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, төсөвт тусгахад бодлогын зөвлөмж гаргах, хэрэгжилтийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Бид бүх үйл ажиллагаандаа хүний эрхийг хамгаалах, эмэгтэйчүүд чадавхижуулах, хүн амын хамгийн ядуу, эмзэг хэсгийн хүмүүсийн боломжийг өргөжүүлэхэд анхаардаг.

Илүү дэлгэрэнгүй мэдээлэл вэбсайтаас үзнэ үү: www.undp.org www.mn.undp.org

Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэлүүд

1997 Хүний хөгжил
2000 Төрийг шинээр зүглүүлэхүй
2003 Хот, хөдөөгийн ялгаатай байдал

2007 Хөдөлмөр эрхлэлт, ядуурал
2011 Эмзэг байдлаас тогтвортой хөгжил рүү: Байгаль орчин, хүний хөгжил
2015 Залуучуудын хөгжилд

HUMAN DEVELOPMENT REPORT MONGOLIA 1997



HUMAN DEVELOPMENT REPORT MONGOLIA 2000



HUMAN DEVELOPMENT REPORT MONGOLIA 2003



MONGOLIA HUMAN DEVELOPMENT REPORT 2007: EMPLOYMENT AND POVERTY IN MONGOLIA



MONGOLIA HUMAN DEVELOPMENT REPORT 2011: FROM VULNERABILITY TO SUSTAINABILITY: ENVIRONMENT AND HUMAN DEVELOPMENT



Photomon agency, R.Enkhbat, G.Erdenetuya.
Фотомон агентлаг, Р.Энхбат, Г.Эрдэнэтуяа.

The Parliament of Mongolia adopted the MDGs as a framework for national policy and planning. This was supported by UNDP. The concept of human development is strongly anchored in Mongolian policy making, and also integral into university curricula. UNDP now focuses on supporting the set-up of a comprehensive national development policy and planning system with a long-term vision and clear development goals for the country. As part of this work, the 2030 Agenda for Sustainable Development is also being integrated and nationalized to the Mongolian development context.

Монгол Улсын Их Хурал МХЗ-уудыг үндэсний хөгжлийн бодлогын хүрээ болгон баталсан бөгөөд НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр хийгдсэн ажил юм. Хүний хөгжлийн концепц нь бодлого боловсруулах явцад болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт нэвтэрсэн. НҮБХХ үндэсний хөгжлийн цогц бодлого төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх, урт хугацааны бодлого боловсруулах явцыг дэмжин ажиллаж байна. 2030 онд хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр нь Монгол Улсын үндэсний түвшинд хэрэгжүүлэх зорилт, хөгжлийн төлөвлөлтөд тусгагдаж байна.



Herders in Tarialan, Uvs Province. UNDP supports community centres for Mongolian herder groups – many herders now develop their own land-use plans, conservation maps and sustainable practices for water, forest and pasture management.

UN Photo/Eskinder Debebe/2009

Увс аймгийн Тариалан сумын малчдын нөхөрлөл. НҮБХХ-ийн дэмжлэгтэй малчдын бүлэг, нөхөрлөлүүд газар, ус, ой, бэлчээрийг тогтвортой хамгаалах арга ажиллагааг төлөвлөх талаар суралцаж байна.

НҮБ/Эскиндер Дебебе/2009

Mongolia now has a National Green Development Strategy that was developed with UNDP support. National and local capacities were strengthened for sustainable use of land, water and forest resources with participation of local communities. Environmental governance has been strengthened in Mongolia, including implementation of international conventions. Climate change adaptation and mitigation is very much the focus of UNDP's programmes. UNDP support the strengthening of the national disaster management system since it helped establish the National Emergency Management Agency in 2004.

Монгол Улсын Ногоон хөгжлийн үндэсний стратегийг боловсруулах, хэрэгжүүлэхэд НҮБХХ дэмжиж ажилласан. Иргэдийн оролцоотой бэлчээр, газар, ус, ойн нөөцийг тогтвортой ашиглах, бодлого хөтөлбөр, олон улсын конвенцийн хэрэгжилт, байгаль орчны засаглалын чадавхи үндэсний болон орон нутгийн түвшинд бэхэжсэн. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, үр дагаврыг сааруулах нь НҮБХХ-ийн хөтөлбөрийн гол чиглэл болж байна. 2004 оноос хойш үүсгэн байгуулагдсанаас хойш НҮБХХ Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)-тай гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний чадавхийг бэхжүүлэхэд нягт хамтран ажиллаж байна.



With support of UNDP, over the past 15 years since its establishment, the National Human Rights Commission of Mongolia (NHRCM) has become a national institution recognized for its leading role in promotion and protecting human rights and preventing human rights abuses.

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс (ХЭ ҮК) байгуулагдсанаасаа хойшхи 15 жилийн хугацаанд хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд манлайлах үүрэг гүйцэтгэн, олон улсын болон үндэсний түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага болсон. НҮБХХ Хүний эрхийн үндэсний комиссыг тууштай дэмжиж, нягт хамтран ажиллаж ирсэн билээ.

Human rights summer course for youth.
National Human Rights Commission/2013

Залуучуудад зориулсан хүний эрхийн зуны сургалт.
Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс/2013

The adoption of the Law on Legal Aid marked an important step towards realization of the right to legal assistance. National Legal Aid Centres are now established all around the country and offer free legal services to suspects of criminal cases who cannot afford legal fees. Women's political empowerment and support to local governance are also key priorities of UNDP's work in Mongolia.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийг баталсан нь иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулахад чухал алхам болсон. НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр хууль зүйн туслалцааны төвийн загварыг туршин, хэрэгжүүлсэн бөгөөд орон даяар байгуулагдан төлбөрийн чадваргүй яллагдагчдад үнэ төлбөргүй хууль зүйн үйлчилгээ үзүүлж байна. Түүнчлэн эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн засаглалыг дэмжих нь НҮБХХ-ийн ажлын нэг гол чиглэл юм.



UNITED NATIONS POPULATION FUND НҮБ-ЫН ХҮН АМЫН САН

For over 30 years, the United Nations Population Fund (UNFPA) has worked with the Government of Mongolia to expand the possibilities for women and young people to lead healthy and productive lives. UNFPA's work in Mongolia is focused on achieving universal access to sexual and reproductive health and rights, promoting gender equality, ensuring every young person's potential is fulfilled, and supporting the collection, dissemination and use of disaggregated population data for the development of policies and programs.

НҮБ-ын Хүн амын сан Монгол улсын Засгийн газартай хамтран эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл энх, бүтээлч амьдрах боломжийг сайжруулахын төлөө сүүлийн 30 гаруй жил хүчин зүтгэж байна. НҮБ-ын Хүн амын сангийн Монгол дахь үйл ажиллагаа нь бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг бүх нийтэд хүртээмжтэй байлгах, жендэрийн тэгш байдлыг хангах, залуу хүн бүрийг хөгжлийн өндөрлөгт хүрэхэд дэмжих, мөн хүн амын талаар нарийвчилсан тоо мэдээлэл цуглуулах, түгээх, тэдгээрийг төрийн бодлого, хөтөлбөр боловсруулахад ашиглах явдлыг дэмжихэд чиглэдэг.



Midwives in Gobi-Altai aimag, Western Region, deliver a healthy baby boy thanks to the Telemedicine Project supported by UNFPA, the Government of Luxembourg and the Government of Mongolia.

Photo: Tim Jenkins/2014

Люксембургийн Засгийн Газар, Монгол Улсын Засгийн Газар, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй Телемедицин төслийн ачаар Говь-Алтай аймгийн эх баригчид бяцхан хүүг эсэн мэнд төрүүлэв.

Фото: Тим Женкинс/2014

UNFPA helps ensure that the sexual and reproductive health and rights of women and young people remain at the center of Mongolia's development. UNFPA is proud to have contributed to Mongolia's 8-fold reduction in maternal mortality since 1992.

Монгол Улс эмэгтэйчүүд, залуучуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлыг ирээдүйн хөгжлийнхөө түлхүүр болгон бодлого хөтөлбөртөө тусгахад нь НҮБ-ын Хүн амын сан тусалдаг. Монголд эхийн эндэгдэл 1992 оноос хойш 8 дахин буурахад хувь нэмэр оруулж чадсан нь НҮБ-ын Хүн амын сангийн бахархал юм.



Young women and men in Bayankhongor Aimag, Central Region, establish their own Y–Peer network to educate their peers on sexual and reproductive health and rights.

Photo: Tim Jenkins /2014

Баянхонгор аймгийн залуучууд үе тэнгийнхэндээ бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн асуудлаар мэдлэг мэдээлэл түгээхээр Үе тэнгийн сургагчдын “Y–Peer” сүлжээг байгуулав.

Фото: Тим Женкинс/2014

Equal rights and opportunities for women and men are critical to Mongolia's development. UNFPA's technical support and advocacy efforts were critical to the adoption of Mongolia's first Law to Promote Gender Equality in 2011, a legal foundation for the elimination of gender-based discrimination and the achievement of gender equality in Mongolia.

Эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш эрх, тэгш боломж эдэлдэг байх нь Монгол Улсын хөгжилд нэн чухал юм. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай анхны хууль 2011 онд батлагдахад НҮБ–ын Хүн амын сангийн мэргэжил, арга зүйн дэмжлэг, нөлөөлөл нэн чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэхүү хууль батлагдсанаар Монголд жендэрт суурилсан ялгаварлал арилж, жендэрийн тэгш байдал хангагдах эрх зүйн үндэс суурь тавигдсан.



An enumerator uses a tablet to interview a woman at her home in Uvs aimag.

Photo: Dustin Barter/2013

Тооллогын ажилтан таблет компьютер ашиглан Увс аймагт оршин суугч эмэгтэйн гэрт нь уулзаж, судалгаа авч байгаа нь. Фото: Дастин Бартер/2013

Everyone Counts! UNFPA has helped to increase the capacity of the National Statistical Office (NSO) and the Government of Mongolia to collect, analyze and use population data. In 2013, UNFPA was instrumental to the NSO's execution of the largest social sample survey in the country's history using cutting edge methods and technology.

Хүн бүрийн талаарх тоо мэдээлэлтэй боллоо! НҮБ-ын Хүн амын сан нь хүн амын тоо мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, ашиглах чадавхийг бэхжүүлэх чиглэлээр Үндэсний статистикийн хороо болон төрийн байгууллагуудыг дэмжиж ажилласан. 2013 онд төрөөс Монголын түүхэн дэхь хамгийн том нийгмийн түүвэр судалгааг сүүлийн үеийн арга зүй, технологи ашиглан зохион байгуулахад НҮБ-ын Хүн амын сан томоохон үүрэг гүйцэтгэсэн.

UNITED NATIONS HUMAN SETTLEMENTS PROGRAMME (UN-HABITAT) НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮН АМЫН НУТАГШИЛ, СУУРЬШЛЫН ХӨТӨЛБӨР (НҮБ-ХАБИТАТ)

UN-Habitat, is the United Nations agency for human settlements, established in 1978 and mandated by the UN General Assembly to promote socially and environmentally sustainable towns and cities with the goal of providing adequate shelter for all.

UN-Habitat has been working in Mongolia since 2006 addressing the larger issues of human settlements and urbanization particularly focusing on Ger area development through integrated and community-led approaches with close cooperation of national and local governments.

UN-Habitat implemented the “Community-Led Ger Area Upgrading in Ulaanbaatar City Project” to improve the lives of 50,000 ger area families through the support of the Government of Japan. UN-Habitat community-led ger area upgrading approach was appreciated and supported by the Municipality of Ulaanbaatar city and has been included in the approaches for Ger area redevelopment and land re-adjustment plans and programmes of the Municipality. UN-Habitat is continuing to support the Municipality of Ulaanbaatar city through the projects “Guidelines for Participatory Urban Development in Ulaanbaatar City”, “Community Engagement Support to Public-Private Partnership in New Ger Area Development in Ulaanbaatar city” and “Community Engagement Support in Ulaanbaatar Urban Services and Ger Areas Development Investment Programme”.

НҮБ-Хабитат нь хүн амын нутагшил, суурьшлын асуудал хариуцсан НҮБ-ын төрөлжсөн агентлаг юм. Тус байгууллага нь 1978 онд байгуулагдсан, хүн бүрийг зохистой орон байраар хангах уриан дор хот, тосгодын нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжиж ажиллах НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээс олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Монгол улсад НҮБ-Хабитат 2006 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд хүн амын суурьшил, хотжилтын асуудлууд, тэр дундаа гэр хорооллыг хосолмол болон оршин суугчдын оролцооны аргаар хөгжүүлэх чиглэлээр төр, орон нутгийн захиргаатай нягт хамтран ажиллаж, “Улаанбаатар хотын гэр хорооллын нөхцөлийг сайжруулах стратеги”-ийг боловсруулж, Япон улсын Засгийн газрын санхүүжилттэйгээр хэрэгжүүлсэн гэр хорооллын 50,000 орчим оршин суугчдын амьдрах орчныг сайжруулахад ашигласан. Төслийн хүрээнд нэвтрүүлсэн иргэдийн оролцоотой нөхцөл сайжруулах аргачлал нь Нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлт болон газар шинэчлэн зохион байгуулах үйл ажиллагаануудад үндсэн аргачлал болон хэрэглэгдэж байна. НҮБ-Хабитатаас “Иргэдийн оролцоотой хот төлөвлөлтийн журам боловсруулах”, “Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд иргэдийн оролцоог хангах”, “Улаанбаатар хотын гэр хороололд дэд төвүүдийг байгуулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрт иргэдийн оролцоог хангах” зэрэг төслүүдийг хэрэгжүүлж байна.



Ger area communities organized under the project identified and prioritized their needs and prepared their action plan to address the most urgent needs to improve their living environment and implemented themselves. Through this empowerment, the communities are now not any more mere receivers of any project and programme's benefits, they are now an important stakeholder for any development activities in their settlement from the planning stage to the completion.

Төслийн хүрээнд зохион байгуулагдсан иргэд амьдрах орчноо сайжруулах хэрэгцээгээ өөрсдөө тодорхойлж ач холбогдлоор нь эрэмбэлэн, шийдвэрлэх үйл ажиллагаагааны төлөвлөгөөгөө өөрсдөө боловсруулж хэрэгжүүлдэг. Ингэснээр иргэд төсөл хөтөлбөрийн үр дүнг зүгээр л хүлээн авагч биш, амьдрах орчинд нь явагдах аливаа хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд төлөвлөлтөөс нь эхлээд хэрэгжүүлж дуусгах хүртэл хамтран оролцох чухал оролцогч тал болоод байгаа билээ.

UNITED NATIONS CHILDREN'S FUND НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САН

UNICEF has worked in Mongolia for over 50 years for the well-being of children through programmes of cooperation with the Government. UNICEF's overall objective is to ensure better equity for all children in Mongolia, especially the most disadvantaged, and the creation of a policy environment for the promotion and protection of their rights. Mongolia presents some unique features such as dispersed population over a vast territory and under extreme climate conditions. This makes service delivery for children very challenging, especially for those living in poverty or in remote areas. Persisting disparities and unaddressed child issues are a priority for UNICEF that seeks to have a sustainable impact by influencing social policies, systems and budgets for children, strongly connected with delivering results for children at the local level.

By helping children reach their full potential, UNICEF contributes to Mongolia's sustainable development and a future built on the most important resource each Country has: its human capital and its new generations.

НҮБ-ын Хүүхдийн сан нь хүүхдийн сайн сайхны төлөө Монгол Улсын Засгийн газартай 50 гаруй жил хамтран ажиллаж байна. НҮБ-ын Хүүхдийн сангийн эрхэм зорилго бол Монголын хүүхэд бүрийн, ялангуяа хамгийн эмзэг бүлгийн хүүхдүүдийн хувьд тэгш байдлыг баталгаажуулах, тэдний эрхийг хангах, хамгаалах эрх зүйн таатай орчинг бий болгоход оршино. Өргөн уудам нутаг дэвсгэрт тархан суурьшсан, цаг агаарын эрс тэс уур амьсгалтай Монгол орны хувьд нийгмийн суурь үйлчилгээг бүх хүүхдэд хүргэх, тур дундаа алслагдсан нутаг оронд амьдарч байгаа, ядуу буурай айл өрхийн хүүхдүүдэд хүргэх нь хүндрэлтэй байдаг. Тиймээс ялгаатай байдлыг арилгах, хүүхдийн шийдэгдэж чадаагүй байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх нь НҮБ-ын Хүүхдийн сангийн тэргүүлэх чиглэл юм. Ингэхдээ илүү тогтвортой, урт хугацааны шийдэл, үр дүнд хүрэхийн тулд бид хүүхэдтэй холбоотой нийгмийн бодлого, тогтолцоо, төсөвт нөлөөлөх, улмаар үүнийгээ орон нутгийн хэмжээнд хүүхдийн төлөө хэрэгжүүлж байгаа ажлын үр дүнтэй холбохыг эрмэлзэж байна.

НҮБ-ын Хүүхдийн сан нь хүүхэд бүрт тэгш хөгжих боломжийг бүрдүүлэхийн төлөө дэмжлэг үзүүлдэг. Энэ нь Монгол Улс өөрийн хамгийн чухал баялаг болох ард иргэд, хойч үе, хүүхэд багачууд дээрээ түшиглэн тогтвортой хөгжил, гэрэлт ирээдүйг цогцлоход нь оруулж буй бидний хувь нэмэр билээ.



Photo: UNICEF Mongolia
Jan Zammit/2015

Фото: НҮБ-ын Хүүхдийн Сан
Жан Заммит/2015

Since 1990 Mongolia made tremendous progress and under-five mortality decreased by 2/3, although inequalities persist. UNICEF works to help address existing disparities, especially between geographic areas and income levels.

1990 оноос хойш Монгол Улс хүүхдийн төлөө үлэмж ахиц дэвшил гаргасны дотор тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 2/3-р бууруулж чадсан нь онцгой амжилт юм. Гэвч тэгш бус байдал байсаар байна. НҮБ-ын Хүүхдийн сан тэгш бус байдал, тэр дундаа газарзүйн байршил болон орлогын ялгаанаас үүдэлтэй тэгш бус байдлыг багасгахын төлөө ажиллаж байна.



Photo: UNICEF Mongolia
Jan Zammit/2015

Фото: НҮБ-ын Хүүхдийн Сан
Жан Заммит/2015

Access to early childhood development has increased from 35 per cent in 1990 to 79 per cent in 2014. Supporting early childhood services is priority for UNICEF as it is a one of the areas with the highest return in building human capital and a foundation for long term development.

1990–2014 оны хооронд сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт 35%-с 79% болж өссөн. Сургуулийн өмнөх боловсролыг дэмжих нь НҮБ-ын Хүүхдийн сангийн нэн тэргүүний зорилт юм. Учир нь ирээдүйн үнэ цэнэтэй хүний нөөц болон урт хугацааны хөгжлийн үндэс суурь нь сургуулийн өмнөх боловсрол байдаг.



Photo: UNICEF Mongolia
Jan Zammit/2015

Фото: НҮБ-ын Хүүхдийн Сан
Жан Заммит/2015

UNICEF supports local development through design and adoption of Child Friendly Community strategies which set targets and indicators for child friendly governance and delivery of inclusive and integrated basic social services for children and families.

НҮБ-ын Хүүхдийн сан нь Хүүхдэд ээлтэй орон нутаг стратегийг боловсруулан, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Энэхүү стратеги нь хүүхдэд ээлтэй засаглал болон нийгмийн цогц суурь үйлчилгээг хүүхэд, гэр бүлд тэгш хүргэх шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон байдаг.



UNITED NATIONS VOLUNTEERS НҮБ-ЫН САЙН ДУРЫН БАЙГУУЛЛАГА

Mission: UNV contributes to peace and development by advocating for recognition of volunteers, working with partners to integrate volunteerism into development programming, and mobilizing an increasing number and diversity of volunteers, including experienced UN Volunteers, throughout the world.

More than 320 international and national UN Volunteers have supported development of Mongolia since 1987.

Deepened interest to develop national volunteer infrastructure in Mongolia through evidence based action and dialogue.

Enhanced recognition on and participation in volunteering by people of Mongolia, in particular youth.

Эрхэм зорилго: НҮБ-ын Сайн дурын хөтөлбөр сайн дурын үйл ажиллагааг сурталчлан таниулахад тусалж дэмжихийн зэрэгцээ, хөгжлийн хөтөлбөрт уг үйл ажиллагааны оролцоог хангаж, тусгахын тулд бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, НҮБ-ын болон дэлхийн олон улс орны сайн дурын үйл ажиллагааг нэгтгэх замаар энх тайван, хөгжил дэвшилд хувь нэмэр оруулдаг юм.

1987 оноос хойш нийт 320 гаруй олон улсын болон үндэсний НҮБ-ын сайн дурынхан Монгол Улсын хөгжилд хувь нэмрээ оруулжээ.

Монгол Улсад үндэсний сайн дурынхны дэд бүтцийг баримтанд суурилсан ажил хэрэг, хэлэлцүүлгээр дамжуулан хөгжүүлэх хүсэл эрмэлзлэл өндөр байна.

Монголын иргэд, ялангуяа залуучуудын сайн дурын идэвх санаачилга, оролцоо нэмэгдэж байна.



A national UN volunteer explains to young audience about the STI & HIV/AIDS prevention during a knowledge sharing event, UNV Mongolia/2007

НҮБ-ын үндэсний сайн дурын ажилтан мэдлэг солилцооны үйл ажиллагааны үеэр БЗХ, ДОХ/ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх талаар залуучуудад тайлбарлаж байна. НҮБ-ын Сайн Дурынхан/2007



A member of UN Youth Advisory Panel talks about the youth role and importance of volunteering for the sustainable development of Mongolia, UNV Mongolia/2014

НҮБ-ын Залуучуудын Зөвлөх Хорооны гишүүн Монгол Улсын тогтвортой хөгжилд залуучуудын оролцоо, сайн дурынхны ач холбогдлын талаар ярьж байна.
НҮБ-ын Сайн Дурынхан/2014



Volunteers clean up streets in commemoration of the World Environment Day.
UNV Mongolia/2006

Сайн дурын ажилтнууд Дэлхийн Байгаль Орчны Өдрийг тэмдэглэж гудамж талбайг цэвэрлэв.
НҮБ-ын Сайн Дурынхан/2006

WORLD HEALTH ORGANIZATION ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

The history of World Health Organization in Mongolia is a story of over half a century of collaboration, going back to 18 April 1962. Over the past five decades, WHO had made significant contributions to implementation of Mongolia's national policies and efforts to improve health and social well-being of the people of Mongolia. WHO supported the country's health system development focusing on reducing maternal and child mortality and morbidity, introducing universal childhood immunization programme, restructuring and financing healthcare services and health insurance, supporting human resource development, strengthening health information systems and establishing multi-sectoral integrated approaches for health promotion.

WHO continues supporting Mongolia through its Ministry of Health and Sports prioritising strengthening of sub-national health systems, supporting access to quality primary health services including essential emergency and surgical care, reducing maternal and infant mortality through introducing early essential newborn care, preventing from non-communicable and communicable diseases, strengthening public health emergency and response, improving environmental and occupational health, supporting technology development, improving essential drugs supply, revising financing mechanisms of health services for vulnerable populations, sustaining immunization financing, developing human resources and managerial capacity and improving licensing and accreditation of health personnel and facilities.

ДЭМБ-ын үйл ажиллагаа Монгол улсад 1962 оны 4-р сарын 18-наас эхлэн өрнөж, 50 гаруй жилийн хамтын ажиллагааны түүхийг бүтээжээ. Өнгөрсөн тавин жилийн туршид ДЭМБ нь эрүүл мэндийн үндэсний бодлогын хэрэгжилтэд тууштай дэмжлэг үзүүлж Монголын хүн амын эрүүл мэнд, сайн сайхны төлөө хүчин чармайлт гарган ажиллаж ирсэн билээ. Энэ хугацаанд ДЭМБ эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах, Дархлаажуулалтын өргөтгөсөн хөтөлбөрийг дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, хүний нөөц, эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн мэдээллийн системийг бэхжүүлэх болон эрүүл мэндийг дэмжих салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулахад анхааран ажиллалаа.

Өдгөө ДЭМБ нь ЭМСЯ-аар дамжуулан Монгол улсад дэмжлэг үзүүлэхдээ орон нутгийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, нэн шаардлагатай яаралтай тусламж бүхий анхан шатны чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох, нярайн эрт үеийн тусламж үйлчилгээг нэвтрүүлснээр эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах, халдварт болон халдварт бус өвчлөлөөс сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн хариу арга хэмжээ авах тогтолцоо, орчны болон хөдөлмөрийн эрүүл мэндийг сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг дэмжих, нэн шаардлагатай эмийн хангамжийг сайжруулах, эмзэг хүн амд хүрэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох, дархлаажуулалтын санхүүжилтийг тогтвортой байлгах, хүний нөөцийн чадавхийг сайжруулах, эрүүл мэндийн салбарын ажилтан, байгууллагууд лизензи авах, магадлан итгэмжлэгдэх үйл ажиллагааг чанаржуулах чиглэлээр ажиллаж байна.



В. Улиатайхуу /1974
Б.Улиатайхүү/1974

WHO helped Mongolia in achieving a dramatic reduction of vaccine preventable diseases such as diphtheria, tetanus and pertussis due to successful implementation of the Expanded Programme on Immunization since 1974.

ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр, Монгол улс Дархлаажуулалтын өргөтсөн хөтөлбөрийг 1974 оноос амжилттай хэрэгжүүлсний үр дүнд сахуу, татран, хөхүүл ханиад зэрэг тарилгаар сэргийлэх боломжтой халдварт өвчнүүд эрс буурч, улмаар устаад байна.



Ch.Urtnasan/2002
Ч.Уртнасан/2002

WHO supported Mongolia in maintaining its polio-free status since 2000, achieving Hepatitis B control through immunization since 2012 and eliminating measles in 2014.

ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр, Монгол улс халдварт саа өвчнийг 2000 онд устгаж, товлолын дархлаажуулалтаар дамжуулан В вирус гепатитын тархалтыг хянах зорилтыг 2012 онд хангаж, улаанбурхан өвчний тархалтыг 2014 онд таслан зогсоосон.



R. Enkhbat/1989
Р.Энхбат /1989

WHO supported Mongolia in setting up a functional mechanism between animal and human health sectors to reduce risk of zoonotic diseases.

Хүний болон мал амьтны эрүүл мэндийн салбар хоорондын үйл ажиллагааны үр дүнтэй механизмыг ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр бүрдүүлснээр зоонозын гаралтай өвчний эрсдлийг бууруулсан.



SUSTAINABLE DEVELOPMENT GOALS

1 NO POVERTY

2 ZERO HUNGER

3 GOOD HEALTH AND WELL-BEING

4 QUALITY EDUCATION

5 GENDER EQUALITY

6 CLEAN WATER AND SANITATION

7 AFFORDABLE AND CLEAN ENERGY

8 DECENT WORK AND ECONOMIC GROWTH

9 INDUSTRY, INNOVATION AND INFRASTRUCTURE

10 REDUCED INEQUALITIES

11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES

12 RESPONSIBLE CONSUMPTION AND PRODUCTION

13 CLIMATE ACTION

14 LIFE BELOW WATER

15 LIFE ON LAND

16 PEACE, JUSTICE AND STRONG INSTITUTIONS

17 PARTNERSHIPS FOR THE GOALS

SUSTAINABLE DEVELOPMENT GOALS